

**ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН 2020 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 03-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮҮРЭГ ДААЛГАВАР
№03**

2020 оны 02 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын даргын өгсөн үүрэг даалгавар	Хариуцах хэлтэс, салбар	Шалгуур үзүүлэлт
1	НЗД-ын 2019.12.25-ны өдрийн “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/1358 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, ажлыг эрчимжүүлэх, захирамжийн заалт бүрээр явц үр дүнг нэгтгэн, ХЕМ-ийн 2020.02.14-ний шуурхай зөвлөгөөнд танилцуулах.	Инженерийн байгууламж хариуцсан дэд дарга бөгөөд ерөнхий инженер, Инженерийн бодлого, хяналтын хэлтэс, Хэрэглэгчийн үйлчилгээ, гэрээ, мониторингийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> • Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
2	“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 02 дугаар сарын 07-ны өдрийн дотор байгуулах.	Захиргаа удирдлан хэлтэс	<ul style="list-style-type: none"> • Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
3	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр ирсэн давтамж хувиргагчийг бүх салбар газрууд 2020 оны 2-р сарын 6-ны дотор суурьлуулж, тохиргоог хийж дуусган, эрчим хүч хэмнэлтийн тооцоог бодитоор хийж 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Инженерийн бодлого, хяналтын хэлтэст ирүүлэх	Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд	<ul style="list-style-type: none"> • Холбох дагалдах цахилгааны материалуудыг захиалгын хуудсаар авах • Тогтоосон хугацаанд суурьлуулж дуусгах • Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
4	Өдөр тутамд хийгдэж байгаа засвар угсралтын ажлын тоног төхөөрөмж, сэлбэг материал зарцуулалтыг өгөгдсөн хүснэгтийн дагуу тайлагнан бичиж, ээлжийн инженерт нэгтгүүлж байх	Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд	<ul style="list-style-type: none"> • Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
5	МУ-ын Засгийн газрын 2020.01.26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолын 10, 11 дүгээр заалтад дурдсан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. 10 дугаар заалт: Амьсгалын замын цочмог халдвар, томуу томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчдад 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох, 11 дүгээр заалт: Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар	Нийт хэлтэс, Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд	<ul style="list-style-type: none"> • Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, • Үр дүн, • Фото зураг /өмнө, дараа/

	өөрийн байгууллагадаа ухуулга сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.		
6	Байгууллагын нэгдсэн бүртгэлийн программ хангамжид оруулах саналаа 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Захиргаа удирдлагын хэлтэст албан бичгээр ирүүлэх.	Нийт хэлтэс, Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд	<ul style="list-style-type: none"> • Тогтоосон хугацаанд ирүүлэх
7	Өөрийн хариуцдаг орон сууцны байр, хотхон, СӨХ-үүдийн нэгдсэн цахим хуудас, группүүдийн судалгааг гарган, нэгдэж байгууллагын тайлан мэдээг, хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээллэж ажилласан тайланг 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлэх.	Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд	<ul style="list-style-type: none"> • Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ • Тогтоосон хугацаанд ирүүлэх

ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
ААЛАГАА